

Хөтөлбөр-4	Зохион байгуулалтын асуудал:				ҮЗЗ	90%	
	• Хяналтын хорооны зарим гишүүдийг чөлөөлж, нөхөн сонгох						
	№	Гишүүний нэр	Албан тушаал	Төлөөлөл (салбар)			Сонгогдсон хугацаа
	1	Ж.Мөнхжаргал	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл Хяналтын хорооны дарга	Төрийн байгууллага			2018-01-31
	2	А.Баярцэцэг	Эрүүд мэндийн чанарын холбоо	Төрийн бус байгууллага			2020-05-15
	3		АШУҮИС Арьс судлалын тэнхим				
4	Г.Нямпүрэв	Залуус Эрүүл Мэнд ТББ	Эрсдэлт бүлгийн төлөөлөл	2018-01-16			
5	С.Энхжин	ЭМЯ-ны мэргэжилтэн	Хяналт шинжилгээ үнэлгээний алба	2018-06-20			

Хөтөлбөр #2 COVID-19 цартахлаас үүдэн Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдэд үзүүлж буй нөлөө

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

COVID-19 цартахлаас үүдэн Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдэд үзүүлж буй нөлөө

Илтгэл 1. COVID-19 цар тахал ба ЭБЭ болон ТЖ нийтийг ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хөтөлбөр: *ЗЭМТ ТББ-ын Гүйцэтгэх захирал-Д.Мягмардорж танилцуулгыг танилцууллаа. /Хавсралт №1/*

Илтгэл 2. Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төсөл 2018-2020: *МСТН-ийн Гүйцэтгэх захирал Б.Гангэрэл танилцуулгыг танилцууллаа. /Хавсралт №2/*

Илтгэл 3. Ковид-19 цартахлаас үүдэн Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөлд үзүүлж буй нөлөө: *ХЗН-ийн Мэргэжилтэн-Гэрэлчимэг танилцуулгыг танилцууллаа. /Хавсралт №3/*

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ТББ	Ч.Сэмжидмаа: 1. ЗЭМТ ТББ-ын Гүйцэтгэх захирал Д.Мягмардорж-с асуулт асууя. Трансжендэр хүмүүсийн эмчилгээ үйлчилгээний стандарт гэж хийж байгаа гэж байсан, энэ ямар байгууллага хийгээд аль шатандаа явж байгаа вэ? 2. ХЗН-с асууя. 2020-2023 оны төлөвлөлт хийж байхад Сүрьеэтэй тэмцэх илрүүлэг тааруу байгаа гэж байсан. 5 шарын цаана Наркалогийн төв гэж байдаг, жилдээ 2500-3000 орчим хүн эмчилдэг. Яагаад энэ газрыг онцолсон гэхээр энд донтсон хүмүүс ханддаг тэнд сүрьеэтэй хүмүүс байхгүй байна гэж бодохгүй байна. Гэвч тэнд барилга байшин, хүн хүч, тоног төхөөрөмж их дутмаг гэж харсан. Тиймээс энэ газрыг дэмжих хүсэлтэй байна мөн энэ газрыг хамруулсан байгаа юу?
ЗЭМТ	Д.Мягмардорж: 2017 онд энэ талаар хийж эхлээд мэдээлэл цуглуулаад ДЭМБ стандарт болоод МУ аль чиглэлийг барих талаар ярилцаад орхисон байсан энэ 5 сард Бүсийн эрүүл мэндийн байгууллагаас стандартын талаар манай төвд мэдээлэл өгсний дагуу одоо үргэлжлээд явж байна.
ХЗН	Н.Цогзолмаа: Илрүүлэг хийх тал дээр нэмэлтээр байгууллагуудыг хамруулахаар яригдаж байгаа хэдий ч үүнд Наркалогийн төвийг хамруулаагүй. Дараагийг төсөл архи, мансууруулах бодист донтогсдын албадан эмчлэх төв дээр Сүрьеэгийн 10-д ортой тусдаа жижиг эмнэлэг баригдаж байгаа, тэрэн дээр хамтарч ажиллахаар тусгаж болох юм.
ҮАБЗ	Ж.Мөнхжаргал: 1. Д.Мягмардорж захиралаас асуулт асууя. Шинээр илрүүлсэн ХДХВ/ ДОХ тохиолдол гарсан гэж

	<p>байна, үүнтэй холбоотой тандалт хийх тал дээр бэрхшээлтэй байгаа байх. Тэр тал дээр ХӨСҮТ-тэй хэр хамтарч ажиллаж байгаа вэ, цаад эзнийг нь олох тал дээр хэр бэрхшээлтэй байна вэ?</p> <p>2. Трансжендэр хүмүүсийн эмчилгээ үйлчилгээний стандарт дээр ҮЗЗ-ийн гишүүд бусад асуудалд хамаатай байгууллага, хүн ам зүйн бодлого хариуцсан яамдын оролцоо байгаа юу?</p> <p>3. Өсвөр насны гэй, транс олон нийт гэрээсээ хөөгдөх, амьдрах газаргүй болох, орлогогүй болох зэрэг бэрхшээл байна гэсэн байсан, үүнтэй холбоотой холбогдох яамдуудад хүсэлт өгсөн байгаа юу, олон хүн байгаа юу?</p> <p>4. Орон байрны архидалт нэмэгдэж, түүнийг дагасан эрсдлүүд бий болж байгаа гэсэн байсан. Энэ тал дээр эрсдэлт бүлэгт ямар байдлаар нөлөөлсөн талаарх судалгаа байна уу?</p> <p>5. МСТН-ийн Гүйцэтгэх захирал Б.Гангэрэл-с асуулт асууя. 21 шинэ сүрьегийн тохиолдол илрүүлсэн гэсэн ямар сүрьегийнх байсан бэ, үүнтэй холбоотой гэр бүлийнхэнээс нь шинжилгээ авсан уу? 35 хүнд хүнсний тусламж олгосон гэж байна. НХХЯам дүүргүүдээр дамжуулан хүнс өгдөг, давхар өгөөд байгаа юм уу эсвэл давхар өгөх шаардлагатай байна уу, хүмүүсээ хэрхэн сонгодог мөн хүнс гэж яг юу өгдөг вэ?</p> <p>6. Арга зүйн дэмжлэг үзүүлж аймгуудаар явсан юм байна, аймгуудаа хэрхэн сонгосон бэ? Ноднин явсан аймгууд харагдаж байх юм.</p> <p>7. 56 хүүхдэд хоол, бэлэг өгсөн гэж байна. Ямар сүрьеэтэй хүмүүс нь гэрээр эм зөөлгөж уудаг юм?</p> <p>8. Цахим мэдээлэл өгсөн гэж байна, энэ бол сайн байна. Гэхдээ энэ хүмүүс дунд ухаалаг утас байтугай зүгээр утас ашиглаж чадахгүй хүмүүс зөндөө байгаа. Энэ хүмүүст хэрхэн хүрч ажилладаг вэ?</p> <p>9. Эм гэрээр хүргэж өгөхдөө өөрсдийгөө хэрхэн хамгаалж байна вэ, өөрсдийгөө хамгаалах тал дээр заавал мөнгө нэхсэн хэрэгслээр биш энгийн аргаар хамгаалах хэрэгслээр шийдэж болдоггүй юм бэ гэсэн эдгээр асуултанд хариулна уу.</p> <p>10. ХЗН-с асуулт байна. Төрийн сангийн гүйлгээ зарцсан гэж өгөгдөл дээрээ өгчихөөд, хэлэхдээ зогссон гэж хэллээ, энэ тал дээр хариулт өгнө үү.</p> <p>11. Ариутгалын бодис авна гэсэн байна. ЭМЯ, Онцгой Байлал, ЗГ-с үүнийг бас авах талаар тусгасан байсан, ингэж давхцуулж авах хэрэг байна уу, энэ яг юуг ариутгах бодис авах гэж байгаа вэ? Хэрэгцээг нь хэн гаргаж байгаа вэ, ямар бодисоор юуг ариутгах гэж байна вэ?</p> <p>12. Алдагдсан сүрьеэгийн тохиолдол гэсэн дээр МУЗН-ийг оруулсан байна. Энэ байгууллага өнөөдрийг хүртэл алдагдсан сүрьеэгийн тохиолдлыг ХӨСҮТ-д авч ирж байсан тохиолдол байна уу, үнэнийг хэлэхэд би санахгүй байна.</p> <p>13. Дижитал рентген аппарат сул зогсож байгаа гэж байна, энэ ямар судалгаагаар хэлсэн бэ? Одоо байгаа рентген аппаратаа хэрэгтэй газар нь зөөж аваачаад шинжилгээ хийх 1 ч удаагийн оролдлого бид нар хийгээгүй.</p>
ЗЭМТ	<p>Д.Мягмардорж:</p> <p>1. Илрүүлсэн ХДХВ-ийн халдварын тоог бид нар шууд ХӨСҮТ-рүү мэдээллэдэг. ХӨСҮТ түүнийг бүртгэж аваад тархвар судлалыг ХӨСҮТ хийдэг. Манайхаас үүн дээр оролцоо байдаггүй. Харин ХДХВ, тэмбүүгийн тохиолдол дээр тухайн өвчтнийг алдахгүй эмчилгээнд хамруулах үйлчилгээг манайх хариуцаж хийдэг.</p> <p>2. Тогтвортой байдлын төслийн хүрээнд хийсэн үнэлгээний зөвлөхүүдийг авахдаа МССМН болон ЭМЯ болон холбогдох байгууллагуудаас зөвөлгөө авч байна уу гэсэн байна. Энэ төсөл маань Австралын зохион байгуулалтын холбоо буюу тухайн байгууллагатай үндсэн хүлээн авагч буюу Глобаль Сангай гэрээлж байгаа, манайх бол салбар хүлээн авагч байгууллага байгаа. Үндсэн хүлээн авагчийн үүрэг дээр нь ҮЗЗ-р хэлэлцүүлнэ гэж ороогүй байсан тул бид нар хэлэлцүүлээгүй, шууд бүстэйгээ холбогдож зөвөлгөө аваад ийм сонгон шалгаруулалт явагдаж байна, алийг нь сонгох талаар бүсээсээ зөвлөгөө авч Үндэсний болон Олон улсын зөвлөхөө зарлаж эцсийн байдлаар бүсээсээ зөвөлгөө авч сонгож байгаа. Хэрвээ бүсээс үндэснийхээ ҮЗЗ-р батлуул гэж чиглэл өгвөл бид цаашид батлуулна.</p> <p>3. Ахмад настны амжиргааны хувьд 3 сараас хойш 15 хүсэлт ирсэн, амжиргааны түвшин доогуур байгаатай холбоотой тусламж хүссэн байсан. 1-т манайх энэ чиглэлийн байгууллага биш, 2-т эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага учир уг хүсэлтийг холбогдох байгууллагууд руу холбож өгсөн. Эхний байдлаар Чехийн олон улсын байгууллага тусламж үзүүлсэн байгаа.</p> <p>4. Орон байрны архидалт өндөр байгаа, үүнийг дагасан өвчлөл өндөр байгааг үгүйсгэхгүй, гэвч бид яг хэн хаана архидаж байгааг мэдэх боломжгүй учир үүнтэй холбоотой хор уршигийн талаар мэдээлэл сурталчилгаа хийх арга хэмжээг авч байгаа.</p>
МСТН	<p>Б.Гангэрэл:</p> <p>1. 21 илрүүлэг гарсан ба эдгээр нь уушигны сүрьеэгийн болон халдварт хэлбэрийн сүрьеэгийн тохиолдолоуд байна. Эдгээр илрүүлэхдээ асуумжийн аргаар илрүүлдэг. Сүрьеэтэй өвчтөнтэй ойр амьдарч байсан хүмүүсээс илрүүлгийн асуумжийг бөглүүлэн авдаг.</p> <p>2. 35 өвчтөнд тусламж үзүүлсэн. Глобаль сангийн төслийн хүрээнд УБ хотод 27, хөдөө орон нутагт 8</p>

	<p>хүнд тусламж үзүүлсэн. Эдгээр хүмүүс нь хороо хорины тодорхойлолттой, дүүргийн диспенсэрийн тодорхойлолттой иргэд байгаа ба үүний үндсэн дээр олгодог байгаа.</p> <p>3. Аргазүйн зөвөлгөөний хувьд Сүрьегийн өвчлөл өндөртэй зүүн 8 аймаг, УБ хотын бүх дүүргүүдэд ажиллаж байгаа. Жилдээ 1 удаа заавал аймгуудаар явж хяналтыг хийх ёстой. УБ хотод бол 7 хоногт 2 удаа хяналт хийдэг.</p> <p>4. Сүрьегээр өвдсөн хүмүүсийн амьдралын түвшин доогуур байдаг. Энэ нь бас нийгмийн гадуурхалттай холбоотой, эдгээр хүмүүс ажилгүй болдог, ажил олдодгүй, орлого байхгүй болдог, гэр бүл үр хүүхдээ тэжээх боломжгүй байдаг. Жишээ нь: Аав нь сүрьеэ өвчтэй байж байгаад эмчилгээ хийлгэж байгаад эдгэсэн боловч 4 хүүхдэд нь сүрьеэ өвчин нь халдсан тохиолдол гарсан. Тиймээс эдгээр гэр бүлд туслах хандивын аян зарлаж тусламж үзүүлсэн.</p> <p>5. Олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгааны хувьд COVID-19 холбоотой айлуудаар явж сургалт сурталчилгаа хийхэд төвөгтэй байгаа учир Facebook-ийг ашиглаж байгаа. Сүрье өвчин нь маш өндөр зардлаар эмчлэгддэг аюултай өвчин байдаг талаар олон нийтэл таниулах сурталчилах зорилгоор Facebook-р мэдээллийг цацах ёстой гэж бодсны үндсэн дээр хийсэн. Яг сүрьетнй өвчтнүүдэд чиглэсэн үү гэхээр бас үгүй, тэр хүмүүст бид идэвхтнүүдээрээ дамжуулан ухуулах хуудас тараадаг.</p> <p>6. Манай сайн дурын идэвхтнүүд маань эрсдэлтэй нөхцөлд ажилладаг. Маскыг өөрсдөө оёод хэрэглэх тал дээр бид нар ярьж байгаа. Гэхдээ бид нар ашгын бус сайн дурын байгууллага тул Глобаль Сангийн төсвийн хүрээнд л үйл ажиллагаагаа явуулдаг учир бас материал авч өөрсдөө маск хийх нь эргээд бас хөрөнгө шаардагдах юм. ҮЗЗ-с үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай зүйл юу байгааг асуусан тиймээс бид шаардлагатай байгаа маскаа энд тусгасан.</p> <p>7. Сүрьегийн талаарх ойлголтыг цахимаар явуулах нь үр дүнтэй байсан цаашид энэ талаар телевиз, радио бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр зорилтот бүлгээс гадна олон нийтэд хүргэх нь зүйтэй гэж үзсэн. Харин зорилтот бүлэгтээ бид ухуулах хуудас тараагаад явж байгаа.</p>
ХЗН	<p>Гэрэлчимэг:</p> <p>1.Төрийн сангийн санхүүжилт зарцсан гэсэн энэ нь хөл хориотой холбоотой сургалт сурталчилгаа, уулзалтын санхүүжилтыг зогсоосон. ХӨСҮТ-ийн Сүрьегийн тандалт судалгааны алба болон бэлгийн замаар халдах халдварын сургалт сурталчилгааны санхүүжилт зогссон юм.</p> <p>2. Ариутгалын бодисын хувьд ЭМЯ, ЗГ-с олгож буй маск болон бусад халдваргүйжүүлэх бодис нь салбар хүлээн авагч байгууллагуудад бол тусгагдаагүй, тиймээс энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг салбар хүлээн авагч байгууллагуудын хүний нөөцөө гар ариутгах бодисоор хангах зорилгоор тусгасан, энэ нь орчныг халдваргүйжүүлэх бодис бол биш юм.</p> <p>3. Улаан загалмай нийгэмлэг ямар тохиолдолуудыг алдагдсан сүрьеэгийн тохиолдолууд гэж үздэг вэ гэхээр ХӨСҮТ-д хяналтанд байж байгаад алдагдсан тохиолдолууд биш юм. Энэрэл гээд эмнэлэг байдаг, энэ нь орон гэргүй сүрьетэй хүмүүст зориулсан эмнэлэг бөгөөд тус эмнэлэгт эмчилгээ хийлгэх явцдаа өвчтөнүүд ирэхгүй алга болох тохиолдол байдаг тэр хүмүүсийг эрэн хайх зорилгоор МУЗН улиралдаа 1 удаа үйл ажиллагаа зохион байгуулдаг. Бид нэмэлтээр энэ жил ХӨСҮТ-ийн хяналтанд байгаад алдагдсан тохиолдолуудыг мөн нэмэлтээр МУЗН оруулах хүсэлт өгсөн үүнтэй холбоотой өмнө 1 удаа явуулдаг байсныг 2 удаа болгох хүсэлт өгсөн.</p> <p>4. Дижитал рентгений сул зогсолттой холбоотой 1 сараас эхлэн хөл хорио тогтоосон үүнтэй холбоотойгоор сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг тэр чигээрээ зогссон. Эдгээр шинжилгээ зогссоны улмаас эдгээр зөөврийн аппаратууд задлаагүй хайрцагтайгаа эмнэлэгүүдэд байгаа, хөл хориотой холбоотой идэвхтэй илрүүлгийг 9 сараас нааш эхлүүлэх боломжгүй болсон. 9 сараас 12 сар хүртэл 4 сарын дотор илрүүлэх ёстой илрүүлгээ бүгдийг нь амжуулж илрүүлэх боломжгүй. Нэгэнт нөхцөл байдал ийм байгаа тул тус аппаратыг эрүүл мэндийн байгууллагуудад үнэ төлбөргүй тавиад хэрэгцээтэй үйл ажиллагаанд нь ашиглуулж байя мөн давхар илрүүлгээ авч байх боломжтой гэж үзэж байна. Эрүүл мэндийн байгууллагууд 14:00 цаг хүртэл рентген зураг авдаг ба дээрээс нь төлбөртэй байдаг, харин зөөврийн рентген аппарат тавьсанаар үнэ төлбөргүй уртасгасан цагаар ажиллах боломжтой болох юм.</p>
ЭМЯ	<p>Т.Энхзаяа:</p> <p>1. Халдваргүйжүүлэлтийн бодис дээр тодруулга хийхэд 2020 онд хийгдэх Халдваргүйжүүлэх бодисын жагсаалт гэж гарсан. Үүнийг 3 яам хамтран баталдаг эдгээр нь ЭМЯ, ХХААЯ, БОАЖЯ бөгөөд судалгаан дээр суурилж хийгддэг. Ялангуяа COVID-19-тэй холбоотой голомтот бүст гадаргуугын ариутгалд хлоридын шингэрүүлсэн уусмал, мөн хүний биед сөрөг нөлөөгүй спиртен суурьтай гар ариутгалын бодисыг зөвлөж байгаа. ЭМЯ 160 сая төгрөгний халдваргүйжүүлэлтийн бодисыг тендер зарлан авсан. Одоо ахин 400 сая төгрөгний халдваргүйжүүлэлтийн бодис авах тендер зарлах гээд хүлээгдэж байна. COVID-19 холбоотой бид эдгээрийг нөөцөлж хадгалж байна, учир нь энэ нь халдвар авахаас урьдчилан сэргийлэх гол хэрэгсэл юм.</p> <p>2. Утастай холбоотой мөн тодруулга хийе гэж бодож байна. Харилцаа холбооны газартай манайх хамтран ажиллаж байгаа ба МУ хэмжээнд 4 сая хүн гар утас хэрэглэж байна гэсэн тоо байгаа ба үүний 80% (3,2 сая) ухаалаг утас, 20% (800,000) энгийн утас хэрэглэдэг гэсэн тооцоо байна. Дэлхий нийтэд</p>

	<p>утсаар дамжуулан мэдээлэл хүргэх хамгийн үр дүнтэй арга гэдэг нь нотлогдсон ба эрүүл мэндийн боловсрол олгодог байгууллагынхаа хувьд гар утас болон сошиал хэрэгсэлээр сурталчилгаа түлхүү явуулж байна. ЭМЯ-с Сүрьеэ, Тэмбүү зэрэг өвчлөлүүдтэй холбоотой зарим сургалтуудаа түр хойшлуулсан байгаа, учир нь COVID-19-тэй холбоотой цаг үеийн тулгамдсан өвчний мэдээллийг өгөх нь илүү чухал байгаа.</p>
МҮЭ	<p>Б.Мягмар: Салбар хүлээн авагч байгууллагуудаас асуух асуулт байна.</p> <p>1. ХЗН-ийн илтгэл дээр Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн биелэлт 23%-32%, цаашдаа ч хэцүү байх талаар ярилаа. Үүнийг биелүүлэхийн тулд цаашид хэрхэн ажиллах вэ, ер нь 2020 оны төлөвлөгөөг биелүүлэхэд хэцүү болох юм биш үү.</p> <p>2. Санхүүжилттэй холбоотой саад бэрхшээл юу байна? МСТН-ийн илтгэл дээр хувь байсангүй, 2020 оны төлөвлөгөө хэдэн хувьтай явж байна вэ, хоцрогдол байна уу, мөн санхүүгийн хувьд саад бэрхшээл байна уу?</p> <p>3. ХЗН-с сургалт сурталчилгааны үйл ажиллагаа нэлээн хоцрогдолтой явагдаж байгаа гэж байсан үүнтэй холбоотой ЭМЯ-тай хэрхэн хамтарч туслалцаа дэмжлэг авах талаар судалсан уу, тус бүрээс нь асууя.</p>
ЗЭМТ	<p>Д.Мягмардорж: 2018-2020 оны төслийн шалгуур үзүүлэлтүүд нь нэлээн өндөр тавигдсан байгаа, дээр нь энэ жил нөхцөл байдал бүр хүнд болчихлоо, бид аль болох бүх боломж бололцоогоо дайчилж ажиллаж байгаа. Энэ 7 сараас Тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд хувь хүн өөрөө өөрийгөө тестлэх тестийг хэрвээ ЭМЯ-тай хамтраад хэрэгжүүлж болох боломжтой болвол энэ нь илрүүлэгт их нэмэртэй болох юм. Энэ нь эмч нь хүмүүсээ хүлээж суух биш хүн хүн дээрээ очих учраас илүү олон хүн дээр очир илрүүлэх боломжтой. Санхүүжилтын хувьд одоогоор бэрхшээл боло байхгүй байна.</p>
МСТН	<p>Б.Гангэрэл: МСТН бол үндсэн 2 шалгуур үзүүлэлтээр ажилладаг. Үндсэн 9 үйл ажиллагаанаас 8 үйл ажиллагаа явагдаж байна, 1 хойшлогдсон үйл ажиллагаа нь хэвлэл мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа байгаа. Илрүүлгийн хувьд манайх шалгуур үзүүлэлтүүддээ хүрч чадахгүй байна. 2019 оны байдлаар 219 хүн илрүүлэхээс 88 илрүүлэгтэй, 2020 оны хувьд 248 хүн илрүүлэхээс 21 илрүүлэгтэй байна. Илрүүлэг маань асуумжаар авагддаг ба гэрээр очиж авагддаг учир удаашралтай байна. Эмийн хүргэлт бол хэвийн явагдаж байгаа, энэ бол жил болгон өндөр 95%-тай байдаг. Санхүүжилтын хувьд бол Глобаль сангаас тогтмол орж ирдэг, хэвийн байгаа.</p>
ХЗН	<p>Гэрэлчимэг: COVID-19-ийн Сүрьегийн төсөл дээр нийт 2 хөтөлбөр боловсруулж байгаа.</p> <p>1. Салбар хүлээн авагч байгууллагууд COVID-19-ийн үед Сүрьегийн өвчтнүүдийн эмчилгээ үйлчилгээг хэрхэн тасалдуулахгүй хэвийн явуулах, COVID-19 халдвар дотоодод тархвал Сүрьегийн тусламж үйлчилгээг хэрхэн яаж явуулах талаар ба одоогоор үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулаад явж байгаа. Үүнийгээ дуусхаар ЭМЯ-р батлуулах юм.</p> <p>2. 2020 оны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтэнд хүрэхэд нэмэлтээр ямар үйл ажиллагаа төлөвлөх талаар ЭМЯ зохих дэмжлэгийг авч ажиллана.</p>
МҮЭ	<p>Б.Мягмар: Сүрьегийн мэргэжилтэн Ганзаяа, Хишигээ гээд зарим хүмүүс нь дутуу байгаа, хүний нөөцөө хэрхэн нөхөж байгаа вэ?</p>
МСТН	<p>Б.Гангэрэл: Ганзаяа мэргэжилтэн ажилдаа буцаад орсон. Хишигээгийн оронд ажиллах хүнийг хайж байгаа.</p>
ШБ	<p>Ж.Одгарьд:</p> <p>1. ХЗН-с асуух асуулт байна. 13%-ийн илрүүлэгтэй явж байна гэж байна. Энэ нь 87% дутуу биелэлттэй ажиллаж байна гэсэн үг, дэлхий дахинд COVID-19-тэй холбоотой бүх албан байгууллага, хувь хүний үйл ажиллагаанд энэ нь сөргөөр нөлөөлж байгаа, үүнээс үүдээд манай шашны байгууллага шинэ зохион байгуулалтанд шилжээд тусгай ажлын хэсэг гарган ажиллаж байна. ХЗН үүнтэй холбоотой ямар арга хэмжээ авч байгаа вэ?</p> <p>2. ЗЭМТ-ийн Мягмардорж-с асуулт асууя. Сүүлийн үед трансжендер, ЭБЭ гэх мэт хүмүүс байх нь хэвийн үзэгдэл, байх ёстой зүйл мэт хандах хандлага нэмэгдэх боллоо, тэдгээр хүмүүсийн нийгэмд үзүүлж буй нөлөөлөлийн талаар бэлгийн гаж хандлага, биеэ үнэлэлтийг бууруулах суртал ухуулгын ажил ер нь хэр хийгдэж байгаа вэ, ЭМЯ үүнийг хэр анхаарч хэрхэн хамтарч ажилладаг вэ?</p> <p>3. МСТН-с асуухад COVID-19 үед сүрьетэй өвчтөнүүдэд энэ нь хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа байнаа уу, мөн ямар арга хэмжээ авч байгаа вэ?</p>
ХЗН	<p>Гэрэлчимэг: Дутуу байгаа 87%-иа гүйцээхийн тулд бид төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа, хамтарч ажилладаг салбар хүлээн авагч нар маань дор бүрнээ үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байгаа хэдий ч COVID-19 холбоотой үүнийг хэрхэн нэмэгдүүлэн ажиллах талаар ярилцсан. МАГА болон МУЗН ХӨСҮТ-тэй хэрхэн хамтарч ажиллаж туслах талаар ярилцаад МУЗН ХӨСҮТ-ийн алдагдсан сүрьегийн тохиолдолыг өөрсдийнхийгөө хайхдаа давхар хариуцаж олж өгөх мөн хөдөө орон нутаг явахдаа мөн хайж өгөх талаар дэмжиж ажиллахаар болсон.</p>

ЗЭМТ	Д.Мягмардорж: Бэлгийн чиг хандлага нь төрөлхийн зүйл байдаг, үүнийг бага байлгах барих бол аргагүй. Бид бол ямар бэлгийн зан үйлтэй байхаас үл хамааран гол нь эрүүл байлгах тал дээр анхаардаг байгууллага. Үүнийг бид байж болно ч гэж үздэггүй болохгүй гэж үздэггүй, үүнээс илүү бэлгийн эрүүл байдлыг хангах үүднээс үзлэг эмчилгээ хийгээд явж байдаг.
МСТН	Б.Гангэрэл: Сүрьеэтэй өвчтөнд COVID-19 хэрхэн нөлөөлж буй талаарх судалгаа одоогоор хийгдээгүй. Сайн дурын ажилтнаар эм зөөлгөж уулгаж байгаа өвчтөнүүд дээр ажиглахад 1 сард 465 байсан бол 3 сард 548 болж өссөн. Эмийг гэрээр явуулахгүй байлгах, асуумж асуухгүй байлгах гэх мэт хүндрэлүүд гарч байгаа. Бил аль болох харьяа дүүрэг, хорооны ажилтнуудтай хамтарч ажиллаж эмийг таслахгүй байх, тогтмол эмээ ууж байгаа эсэх дээх хяналт тавьж ажиллаж байна. Илрүүлгийн хувьд бол муу хангалтгүй байгаа, үүнийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллаж байгаа.
ҮАБЗ	Ж.Мөнхжаргал: Сорьц тээвэрлэх үйл ажиллагаагаа өргөтгөх санал тавьж байна. Дижитал рентген аппарат хайрцагандаа байгаа гээд байгаа нь оновчгүй санагдаж байна, ЭМСайд нь одоо болтол үүнийг хайрцаганд нь байлгаж байгаа гэж бодохгүй байна, баримт нотолгоогүй ийм юм ярьмааргүй байна. Дижитал рентген аппаратыг ЭМЯ юм уу холбогдох эмнэлэгийн удирдлагуудад хандаж хоорондын үйл ажиллагаагаа уялдуулах хэрэгтэй гэсэн санал тавьж байна. Халдваргүйжүүлэх бодис дээр цаашид хлоргүй ионжуулсан бодис авах тал дээр анхаарвал, Монголд ионжуулсан халдваргүйжүүлэлтийн бодис үйлдвэрлэж байгаа, үүнийг худалдан авах тал дээр судлах санал оруулж байна. Хоол хүнд өгч байгаа, төрийн үйлчилгээ дутагдаад байгаа газар ТББ нь юу дутагдаад байгааг судлаад хэрэгтэй юмаар нь хангах тал анхаарах хэрэгтэй гэсэн саналтай байна.
ЗЭМТ	Г.Нямпүрэв: COVID-19-той холбоотой төлөвлөгөө, индикатортаа хүрэхгүй болох нь тодорхой болсон, ийм үед Монгол улс өөрөө Эрсдэлээс хамгаалах төлөвлөгөөтэй байгаа, үүн дээр юу гэж заасан байгаа вэ?
ХЗН	Н.Цогзолмаа: Энэ төлөвлөгөө нь 2019 оноос яригдаж эхлээд хийгдэж байгаа ба одоог хүртэл дуусаагүй байгаа.
ХЭҮК	Ц.Адьяахишиг: Одгарьд гишүүний хэлсэн саналтай санал нэг байна. COVID-19-той холбоотой зочид буудлууд хаагдсанаас өсвөр насны гей, трансжендер хүмүүс орлогогүй болж байна гэж хэлж байгаа нь хэрвээ нийгэмд тарвал энэ нь эргээд нийгэм бүр жигших, үзэн ядах хандлагыг бий болгох аюултай. COVID-19 анх 1 сард дэгдсэн үүнээс хойш 5 сар одоо бараг 6 сар гарах гэж байхад бидэнд ямар ч төлөвлөгөө алга байна, хэзээ энэ төлөвлөгөө хийгдэж батлагдаж хэрэгжих вэ? Энэ тал дээр ХЗН анхаармаар санагдаж байна.
ЭМЯ-УХА	Б.Цогтбаатар: COVID-19 гэж шинэ өвчин дэгдэж дэлхий даяар үүний нөлөөнд автаж байгаа. Гэвч бид Глобаль Сангаас санхүүжилт авч үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээсэн төлөвлөгөө, нормтой гэрээ хийсэн байгууллага юм. Үүссэн нөхцөл байдал үүнд нөлөөлж байгаа гэвч энэ нь төлөвлөгөөнд хүрэхгүй байх тайлбар болох боломжгүй. Тиймээс үүссэн нөхцөл байдалтай уялдуулаад хэрхэн үйл ажиллагаагаа өөрчилж, шинэ арга барил боломжуудаар ажиллаж болох боломжуудыг судлах нь зүйтэй. МСТН-ийн үйл ажиллагаа доголдож байгаа нь аргагүй, гэрээр эм хүргэж уулгах нь битгий хэл, сонгуулийн сурталчилгааг хүртэл гэрээр очиж хийхийг хориглочихсон. Гэвч эдгээр хүмүүсийн эмийг хэрхэн таслахгүй хүргэх тал дээр холбогдох хороо, дүүргийн эмч мэргэжилтнүүдтэй зөвлөлдөөд явж байгаа гэж бодож байна. Асуумжаар илрүүлэх үйл ажиллагаа маш хэцүү болж байгааг ойлгож байна, шаардлага байна уу гэж бодогдож байна. ХЗН-ийн танилцуулга дээр Сонгууль 6 сарын 24-нд болно гээд ороод ирсэн байна, энэ үйл ажиллагаатай ямар холбоотой вэ, цаашид иймэрхүү мэргэжлийн бус хандлагатай баймааргүй байна.
МҮЭ	Б.Мягмар: Санал хэлж, танилцуулга тавьсан та бүхэнд баярлалаа. Гол санаа зовж байсан, өмнө нь асуудал болдог байсан санхүүжилтийн асуудал маань хэвийн байгаа, одоо харин COVID-19, сонгууль гэсэн шалтаг тоочихгүйгээр үндсэн үйл ажиллагаагаа сайн явуулах тал дээр анхаарах, 200 илрүүлэг хийхээс өнөөдөр 21-тэй байж байна гэдэг маш хангалтгүй байгаа нь харагдаж байна. ЭМЯ, ХЗН, салбар хүлээн авагч гээд аль аль талдаа боломжит бүх байдлаараа сайн шахаж ажиллах хэрэгтэй байна. Үүнийг шүүмж биш зөвлөмж байдлаар хэлж байгаа юм шүү. Бид үйл ажиллагаатай холбоотой санхүүжилтийг хасах танах, зогсоох зэрэг байдал гаргаагүй харин, ханшийн зөрүү, ханган нийлүүлэлтийн хэмнэлт зэргээс гарсан санхүүжилтээр үйл ажиллагааг дахин төлөвлөсөн. Иймээс эдгээр нь ХЗН болон бусад салбар хүлээн авагчийн санхүүжилтэнд огт нөлөөлөхгүйгээр шийдсэн учир та бүхэн ҮЗЗ-ийн гишүүдээс хэлсэн санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган ажиллаарай гэж дүгнэж хэлмээр байна.
Шийдвэр:	
Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар	

Зөвшилцөл	х		
Санал хураалт		Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх
		Дэмжсэн>	Нууц санал хураалт
		Эсрэг>	
			Санал өгөхөөс түдгэлзэх

Хөтөлбөр #3 Глобаль сангийн C19RM механизмын талаар танилцуулах

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Глобаль сангийн C19RM механизмын талаар танилцуулах

ҮЗЗ-ийн Ажлын албаны зохицуулагч Б.Оюундарь болон ЭМЯ, ЭҮТГ-ын Мэргэжилтэн Х.Өлзий-Орших нар танилцуулгыг танилцууллаа. /Хавсралт №4,5/

Танилцуулгын товч хураангуй

COVID 19 Response Mechanism (C19RM)

- C19RM болох шинэ механизм нь COVID-19 тэмцэх замаар ХДХВ болон сүрьеэгийн хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахад болон эрүүл мэндийн тогтолцоог яаралтай сайжруулахад чиглэгдэх юм.
- C19RM нь 500 сая ам.долларын санхүүжилтийг босгосон
- Улс орнууд C19RM механизмаас 2020-2022 оны санхүүжилтийн 10 хүртэлх хувийн санхүүжилтийн дэмжлэг авах боломжтой
- Үүнээс хөтөлбөрүүдийн санхүүжилтээс гаргасан дүнг хасах юм (-5%)

Монгол улсын хувьд:

- Санхүүжилтийн хүсэлт бичиж боловсруулах
- Тэргүүлэх чиглэл 1: 2020-2022 оны нийт санхүүжилтийн 3.25%-тай тэнцэх **13,344,330\$ (433,690\$)**
- Тэргүүлэх чиглэл 2: Тэргүүлэх чиглэл 1 болон төслийн хэмнэгдсэн санхүүжлт 5%-ийн хүсэлтийг хасаад үлдсэн нь **382,358\$**
- 2020 оны 5-р сарын 31-нээс өмнө Глобаль санд илгээх

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

МҮЭ **Б.Мягмар:** МУ-ын хувьд ГС-ын C19M гэсэн шинэ механизмаас нэмэлт 10% үүнээс хөтөлбөрүүдийн санхүүжилтийг хасаад 5%-ийн санхүүжилт авах боломжтой. Үүн дээр ҮЗЗ-ийн гол гол гишүүд болох ДЭМБ, ЭМЯ-ны төлөөлөлүүдийн саналыг сонсох нь зүйтэй байх.

ЭМЯ-УХА **Б.Цогтбаатар:** Бидний өмнө баталсан 171,560 ам.долларын санхүүжилт нь маш их нэмэртэй байгаа, одоогоор шууд үр шим нь харагдахгүй байгаа ч гэсэн. ГС-аас бидэнд өөр боломж олгож байна, цаашид хэрэгцээ улам нэмэгдэнэ. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг бид одоогоор сайн хэрэгжүүлж байгаа, харин одоо бид хурдан оношлох оношлуурын асуудал мөн өвдсөн хүнээ түргэн эмчлэх 2 асуудал тулгамдаж байна. Оношлуурын асуудал дээр ЗГ болон ДЭМБ-с багагүй хөрөнгө шийдэж авсан боловч нөөц маань дууссан. Оношлуур нь одоогоор бүх улс орнуудад маш их эрэлттэй байгаа учир үнэ нь төдийлөн буухгүй байгаа, оношлуур нь дотроо үндсэн оношлуур, өвөрмөц оношлуур гэсэн 2 төрөл байгаа. Өвөрмөц оношлуурыг ДЭМБ-ын санхүүжилтээр аваад явж байна. Үндсэн оношлуурын хэрэгцээ маш их байгаа нийт 50,000 ш оношлуур шаардлагатай байгаагаас, хэрэгцээтэй оношлуурын 20,000 ш орчмыг ГС-ийн санхүүжилтээр авах тал дээр ЭМЯ-ны сайдын түвшинд яригдсан байгааг уламжилж байна.

МҮЭ **Б.Мягмар:** ГС-ийн шинэ механизмаас нэмэлт санхүүжилт авах тал дээр ЭМЯ-ний сайд нь хүсэлт гаргасан байгаа бол бодлого барьж байгаа яам нь адилхан байгаа байх, тиймээс одоо энэхүү хүсэлтийг хэн, ямар байгууллага хариуцаж хийх вэ гэсэн асуудлаа ярилцая. ХЗН COVID-19-той холбоотой ажлын

	ачаалал маш их байгаа. Тиймээс Энхзаяа дарга та амлалт, үүрэг авах уу?		
ТБ	Т.Энхзаяа: Цогтбаатар даргатай санал нэг байна, оношлуурын асуудал дээр. Оношлуур, маск, халдваргүйжүүлэлтийн бодис зэрэг асуудлыг ЭМЯ-ний Эм үйлдвэрлэл, технологийн хэлтэс энэ асуудлыг хариуцаж байгаа, тиймээс цаашид хариуцаад явах байх. Харин бичиг баримт боловсруулалтын хувьд манай хэлтэс бүх талаараа хамтрахад бэлэн байна.		
МҮЭ	Б.Мягмар: ЭМЯ-с ГС-ийн шинэ механизмаас нэмэлт санхүүжилт авах бичиг баримтыг боловсруулж ажиллах хүсэлт гаргалаа. Үүн дээр ҮЗЗ-ийн гишүүд дэмжих эсэх дээр санал хураая.		
МАОЭХ	Х.Ганбаатар: COVID-19-тэй холбоотой ГС-с нэмэлт санхүүжилт авах асуудлыг бүрэн дэмжиж байна. Харин 5 сарын 31-с гэхэд бүх бичиг баримтаа боловсруулаад өргөн барих асуудал тулгамдаж байна, үндсэндээ ажлын 5 хоногын дотор боловсруулах шаардлагатай юм байна. Тиймээс үүн дээр хэлтэй нэмэлт мэргэжилтнүүдийн оруулах, бусад гадаадын өргөн барьсан жишиг төслөөс санаа авах зэргээр яаралтай арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байна.		
МҮЭ	Б.Мягмар: ГС-ийн С19М шинэ механизмын тэргүүлэх чиглэл 1: 433,690\$ тэргүүлэх чиглэл 2: 382,358\$ гэсэн 2 чиглэл дээр аль алин дээр нь хүсэлт явуулах дээр ҮЗЗ-ийн гишүүдээс санал хураая.		
ҮАБЗ	Ж.Мөнхжаргал: Би татгалзаж байна. Учир нь Gene expert-ийн нэрлэсэн оношлуур нь 4, 4-хөн сорьцоор орно энэ нь био аюулгүй байдлын хувьд таарахгүй. Хэрвээ ДЭМБ-с зөвлөж байгаа оношлуураа авах бол би дэмжинэ.		
ЭМЯ-УХА	Б.Цогтбаатар: Энд Gene Expert-ийн оношлуур биш PCR-ийн оношлуур авах талаар яригдаж байгаа, энэ нь ДЭМБ-с зөвлөсөн оношлуур юм. Энд ямар нэг нэрлэсэн брэндийн нэрлэсэн оношлуур байхгүй.		
ШБ	Ж.Одгарьд: Өнгөрсөн Zoom болон Гүйцэтгэх хорооны хурлууд дээр энэ шинэ нэмэлт санхүүжилтийг бүгдийг нь авах хүсэлт гаргасан. Одоо бидэнд цаг бага байна. Тиймээс гол бодлого барьж буй ЭМЯ нь төслөө бичээд гарах үр дүнгээ тооцоод хийх нт зүйтэй байх, бидний зүгээс дэмжлэг хэрэгтэй бол хамтран ажиллахад бэлэн байна.		
МҮЭ	Б.Мягмар: Одгарьд гишүүн чухал санал хэллээ. Нэгэнт нэмэлт санхүүжилт авах боломж гарсан учир хүсэлтээ өгөх нь зүйтэй. Энэ бодлого чиглэлийг цаашид 1 хүнд хариуцуулах нь зүйтэй гэж үзэж байна. Тиймээс Цогтбаатар даргад энэхүү үүргийг хариуцуулсан нь зөв байх.		
Зөвлөмж:			
Шийдвэр:			
Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар			
Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх Нууц санал хураалт
		Дэмжсэн>	14/15
		Эсрэг>	
		Санал өгөхөөс түдгэлзэх	
Хөтөлбөр #4	ҮЗЗ-ийн даргыг сонгох		
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.			
Байхгүй			
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>			Үгүй
Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга			
МҮЭ	Б.Мягмар: ҮЗЗ-ийн шинэ даргыг сонгох асуудлыг хэлэлцэе. Миний бие анх 2017 онд ҮЗЗ-ийн гишүүнээр ороод ажиллаж байх хугацаанд Мөнхцэцэг дарга маань жирэмсний амралтаа авах болоод намайг түр ажилуулахаар үлдээсэн. Түүнээс хойш Мөнхцэцэг дарга маань ажилдаа орсон ч намайг үргэлжлүүлэн ажиллахыг хүссэн, хэдийгээр ҮЗЗ-ийн даргаар ажиллах хугацаа дууссан боловч шинэ төсөл өргөн барих, COVID-19-той холбоотой дахин төлөвлөлт зэрэг асуудлууд гарч ирсэн тул түр хугацаанд ажиллаж, өнөөдөр өөрийх хүсэлтээр ажлаа хүлээлгэн өгч байна. Ингээд шинэ даргад нэр дэвшигч нарын талаарх мэдээллийг Ажлын албаны Оюундарь танилцуулна.		

ҮЗЗ-АА	Б.Оюундарь: Zoom application-р хийгдсэн 2020/05/11-нд болсон 84 дэх удаагийн хурлаар уг асуудлыг хэлэлцэх байсан ч үүнийг энэ удаагийн хурлаар хэлэлцүүлэхээр хойшлуулан, 5 сарын 18-ний дотор нэр дэвших гишүүдийн саналыг авах үүргийг Ажлын албанд өгсөн. Үүний дагуу 2 гишүүний нэрийг дэвшүүлсэн. (ҮЗЗ-ийн дарга сонгохтой холбоотой ҮЗЗ-ийн дүрмийн холбогдох заалтыг гишүүдэд танилцуулав)		
ЭМЯ-УХА	Б.Цогтбаатар: ҮЗЗ-ийн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ цугласан байгаа учир танхимаас нэр дэвших боломж нээлттэй. ЗЭМТ Г.Нямпүрэв: COVID-19-той холбоотой төлөвлөгөө, индикатортаа хүрэхгүй болох нь тодорхой болсон, ийм үед Монгол улс өөрөө Эрсдэлээс хамгаалах төлөвлөгөөтэй байгаа, үүн дээр юу гэж заасан байгаа вэ?		
ЗЭМТ	Г.Нямпүрэв: Миний хувьд ажлын туршлагатай, удирдах чадвартай гэдэг үүднээс АОЭХолбооны дарга Х.Ганбаатар даргын нэрийг дэвшүүлмээр байна.		
ЭМЯ-УХА	Б.Цогтбаатар: Саналыг бүртгэж авлаа. Нийт 3 нэр дэвшигч болж байна. 1. Ж.Одгарьд 2. Б.Дамдиндорж 3. Х.Ганбаатар		
МҮЭ	Б.Мягмар: Өөр нэр дэвшүүлэх санал байна уу? Байхгүй бол нэр дэвших ажиллагааг хааж байна. 3 нэр дэвшигч өөрсдийгөө гишүүдэд танилцуулна уу.		
Нэр дэвшигч	1. Ж.Одгарьд 2. Б.Дамдиндорж 3. Х.Ганбаатар гишүүд тус бүр өөрсдийгөө танилцууллаа.		
МҮЭ	Б.Мягмар: Гишүүдэд өгсөн хавтсанд санал бичих цаас хийсэн, уг цаасан дээр сонгож буй гишүүнийхээ нэрийг бичээд санал хураах хайрцаганд хийнэ үү.		
Зөвлөмж:			
Шийдвэр: ҮЗЗ-ийн нийт оролцсон гишүүдээс ҮЗЗ дарга сонгох саналыг нууц санал хураалтаар явуулж, нийт гишүүдийн өмнө саналыг тоолж дүнг зарлав. 1. Ж.Одгарьд-4 санал 2. Б.Дамдиндорж-0 санал 3. Х.Ганбаатар-11 саналтайгаар дараагийн ҮЗЗ-ийн даргаар сонгогдлоо.			
Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар			
Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх
		Нууц санал хураалт	х
		Дэмжсэн>	15
		Эсрэг>	
		Санал өгөхөөс түдгэлзэх	
Хөтөлбөр #5	Бусад асуудал		
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.			
Байхгүй			
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (гийм эсвэл үгүй)>			Үгүй
Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга			
МҮЭ	Б.Мягмар: ҮЗЗ-ийн Ажлын албаны зохицуулагч Б.Оюундарь ҮЗЗ-ийн дарга надад өргөдөл хүсэлт ирүүлснийг танилцуулж байна. (Өргөдөлийг хавсаргав) Өргөдөлийн хураангуй: ҮЗЗ-ийн гишүүдээс дэмжлэг хүсэх тухай: ҮЗЗ-ийн Ажлын албаны зохицуулагч Б.Оюундарь миний бие 2014 оноос хойш Глобал Сангийн ҮЗЗ-ийн Ажлын албанд ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд 3 удаагийн төслийг Глобал санд амжилттай өргөн барьсан. Миний бие мэдлэг боловсролоо дээшлүүлэх үүднээс 2020 оны 9 сараас Итали улсын Global Campus Europe Их сургуульд Хүний		

	<p>эрхийн чиглэлээр Магистрын 1 жилийн хөтөлбөрт суралцах хүсэлт гарган тэнцсэн ба үүнтэй холбоотой сургалтын төлбөр болох 5650 еврогийн төлбөр дээр дэмжлэг үзүүлэх талаар та бүхний дэмжлэгийг хүсч байна.Төгсч ирээд Глобаль Сангийн ҮЗЗ-ийн Ажлын албандаа буцаж ирээд үргэлжлүүлэн хичээнгүйлэн ажиллах болно.</p> <p>ҮЗЗ-ийн Ажлын албаны зохицуулагч Б.Оюундарь нь өнгөрсөн хугацаанд хичээнгүйлэн ажиллаж ирсэн бөгөөд үндсэн Олон улс судлалын мэргэжилээсээ гадна ахин Хүний эрхийн чиглэлээр суралцаж хос мэргэжилтэй болсон. Тус суралцах гэж буй хөтөлбөр нь тэтгэлэг олгох боломжтой хөтөлбөр байсан боловч COVID-19-той холбоотой цуцлагдсан юм байна. Үүнтэй холбоотой ҮЗЗ-ийн гишүүдийнхээ саналыг сонсьё.</p>
АОЭХ	Х.Ганбаатар: 5650 евро нь зөвхөн сургалтын төлбөр үү, бусад зардал нь багтсан байгаа юу? Ганцхан сургалтын төлбөр гэвэл амьдрах байр, хоол унд гэсэн зардал нь бас хэцүү, нэгэнт шийдвэр гаргаж байгаа бол цуг оруулвал уул нь.
МҮЭ	Б.Мягмар: Зөвхөн сургалтын төлбөрийн дэмжлэг хүссэн. Бусад зардалаа өөрөө даахаар болсон.
ЗЭМТ	Г.Нямпүрэв: Бидэнд гаргах санхүүжилт байгаа юу? ҮЗЗ-ийн гишүүдэд ийм боломж мөн байдаг уу?
МҮЭ	Б.Мягмар: Санхүүжилтын талаар боломж байгаа талаар Б.Оюундариар судлуулсан. Энэ 7 сард зохиогдох байсан олон улсын хурал, сургалт гэсэн 7000\$-ийн санхүүжилтийн нөөц байгаа юм байна.
ҮАБЗ	Ж.Мөнхжаргал: Б.Оюундарьтай бид олон жил хамтарч ажилласан. Боломж бололцоо нь байгаа бол дэмжих саналтай байна.
ХЭҮК	Адьяахишиг: Төлөвлөсөн зардалыг өөр зүйл зарцуулахад асуудал үүсэх үү? Болон нь байвал дэмжье.
МҮЭ	Б.Мягмар: ҮЗЗ-ийн гишүүд дэмжсэн тохиолдолд асуудал үүсэхгүй. Энэ нь цаашаа Глобаль Сан руу явж хянагдаад шийдэгдэнэ. Эцсийн шийдвэрийг Глобаль Сангаас гаргана.
ТББ	Ч.Сэмжидмаа: Гол нь суралцаж ирээд буцаж ирж ажиллах тал дээр гэрээ хийх нь зүйтэй гэж бодож байна.
МҮЭ	Б.Мягмар: ҮЗЗ-ийн шинэ дарга нь ҮЗЗ-ийн Ажлын албаны зохицуулагч Б.Оюундарьтай гэрээ хийж, хэрвээ Глобаль Сангийн дэмжлэгтэй суралцаж ирээд ажиллах, хэрвээ ажиллахгүй бол сургалтын төлбөрийг буцааж төлж Глобаль Санг хохиролгүй болгох гэрээ хийх юм. Ингээд сургалтын төлбөрийн дэмжлэг олгох эсэх дээр гишүүдээс санал хураая.

Зөвлөмж:

Шийдвэр:

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх Нууц санал хураалт
		Дэмжсэн>	15/15
		Эсрэг>	
		Санал өгөхөөс түдгэлзэх	

ШИЙДВЭР, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	ХУГАЦАА
Хөтөлбөр #1	Өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулсан	ҮЗЗ Ажлын алба	
Хөтөлбөр #2	ХЗН, МСТН, ЗЭМТ болон бусад салбар хүлээн авагч байгууллагууд COVID-19 холбоотой цаг үеийн нөхцөл байдалтай уялдан үйл ажиллагааны арга барилаа шинэчлэн, тавьсан зорилтот төлөвлөгөөндөө хүрэхийн тулд бүхий л боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар ҮЗЗ-ийн гишүүд санал, зөвлөмж өглөө.	ХЗН, МСТН, ЗЭМТ	

Хөтөлбөр #3	<p>COVID-19-тэй холбоотой ГС-с шинээр байгуулсан С19М механизмийн нэмэлт санхүүжилт болох:</p> <p>Тэргүүлэх чиглэл 1: 2020-2022 оны нийт санхүүжилтийн 3.25%-тай тэнцэх 13,344,330\$ (433,690\$)</p> <p>Тэргүүлэх чиглэл 2: Тэргүүлэх чиглэл 1 болон төслийн хэмнэгдсэн санхүүжилт 5%-ийн хүсэлтийг хасаад үлдсэн нь 382,358\$ авах 2 саналыг ҮЗЗ-ийн 85 дахь удаагийн хуралд оролцсон 15 гишүүнээс 14 гишүүн дэмжин баталлаа.</p> <p>Төслийг үндсэн хүлээн авагч болох ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, ҮЗЗ-ийн дэд дарга-Б.Цогтбаатар удирдан Эм үйлдвэрлэл, технологийн хэлтэс болон Нийгмийн эрүүл мэндийн газартай хамтран боловсруулж 2020 оны 5-р сарын 31-нээс өмнө Глобал санд илгээхээр шийдвэрлэлээ.</p>	ХЗН, ҮЗЗ Ажлын алба	
Хөтөлбөр #4	<p>ҮЗЗ-ийн шинэ даргад нийт 3 гишүүн нэр дэвшүүлсэн. ҮЗЗ-ийн 15 гишүүн оролцсон, саналыг нууц санал хураалтаар явуулж, нийт гишүүдийн өмнө саналыг тоолж дүнг зарлав.</p> <p>1. Ж.Одгарьд-4 санал 2. Б.Дамдиндорж-0 санал 3. Х.Ганбаатар-11 саналтайгаар дараагийн ҮЗЗ-ийн даргаар сонгогдлоо.</p>	ҮЗЗ-ийн гишүүд	
Бусад	<p>ҮЗЗ-ийн Ажлын албаны зохицуулагч Б.Оюундарь ҮЗЗ-ийн даргад Магистрын сургалтын төлбөрийн дэмжлэг хүссэн өргөдөл өгсний дагуу ҮЗЗ-ийн гишүүдэд танилцуулсан. Хуралд оролцсон ҮЗЗ-ийн 15 гишүүн бүгд дэмжин баталлаа.</p> <p>ҮЗЗ-ийн шинэ дарга, ҮЗЗ-ийн Ажлын албаны зохицуулагч Б.Оюундарьтай гэрээ хийж хэрвээ Глобал Сангийн дэмжлэгтэй суралцаад буцаж ирж ажиллахгүй тохиолдолд сургалтын төлбөрийг буцааж төлж Глобал Санг хохиролгүй болгох гэрээ хийхээр шийдвэрлэлээ.</p>	ҮЗЗ-ийн гишүүд	

ДАРААГИЙН ХУРАЛ (ОГНОО, ХӨТӨЛБӨР)

Огноо	
Хэлэлцэх асуудлууд	Хөтөлбөр

Хавсрах материал	Тохирох нүдийг бөглөнө үү	
	Тийм	Үгүй
Оролцогчдын бүртгэл	x	
Хөтөлбөр	x	
Бусад /илтгэлүүд/	x	
Хавсралт 1, 2	x	

БЭЛТГЭЛ АЖИЛ (Тохирох нүдийг бөглөнө үү)

	Тийм	Үгүй	
Хурлын тов, хөтөлбөрийг хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлсэн эсэх	x		14 болон 7 хоног
Бүртгэлийн хуудас	x		Хуралд оролцсон бүх хүмүүс
Хурлын тэмдэглэлийг хурал болсоноос 7 хоногийн дотор явуулах	x		7 хоног
Хүргүүлсэн тэмдэглэлд гишүүд саналаа өгөх, нэмэх, батлах	x		Цахим хаягаар
Хурлын тэмдэглэлийг гишүүд болон орлож ирсэн төлөөлөлд хүргүүлж байх	x		ҮЗЗ-ийн цахим хуудсанд 15 хоногийн дотор байршуулах

ТОВЧИЛСОН ҮГ:

Товчлол	Утга
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам

ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл
ТБ	Төрийн Байгууллага
ҮЗЗ	Үндэсний Зорицуулах Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ХЗН	Хөтөлбөр Зохицуулах Нэгж
МСТН	Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нийгэмлэг
МУЗН	Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг
НХХЯ	Нийгэм Хамгаалал Хөдөлмөрийн Яам
ХХААЯ	Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
ХХ	Хяналтын Хороо
ГХ	Гүйцэтгэх Хороо
ШБ	Шашины Байгууллага
ЗЭМТ	Залуус Эрүүл Мэнд Төв
МАОЭХ	Монголын Ажил Олгогч Эздийн Холбоо

БАТАЛСАН:

Нэр>	Х.Ганбаатар	Огноо>	2020 оны 05 сарын 26
Албан тушаал>	ҮЗЗ-ийн дарга	Гарын үсэг>	

ХЯНАСАН:

Нэр>	Б.Оюундарь	Огноо>	2020 оны 05 сарын 26
Албан тушаал>	ҮЗЗ-ийн зохицуулагч	Гарын үсэг>	

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Нэр>	Т.Батчимэг	Огноо>	2020 оны 05 сарын 26
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	